



ИНД-140

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

**Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага -
Гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-140 нь Монгол Улсад нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхийг зорьж буй байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон тухайн гэрчилгээг хадгалах үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

ИНД-140-ийг, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Хавсралт 17-ийн дагуу Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх, дараах байгууллагад аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх зорилгоор боловсруулсан:

- аюулгүйн хамгаалалттай аэродромд;
- аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид.

ИНД-140-ийг, байгууллагын гэрчилгээжүүлэлттэй холбоотой дүрмийн стандарт загвараар боловсруулсан ба энэ загвар нь гэрчилгээжүүлэлтийн (босго стандарт), үйл ажиллагааны (байнгын үйл ажиллагаа) болон аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхэлж буй этгээдэд аюулгүй ажиллагааны аудит хийх (байнгын хяналт) тусгай шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-140-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-140, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2002 оны 12 сарын 20
Нэмэлт, өөрчлөлт 1	2010 оны 06 сарын 17
Нэмэлт, өөрчлөлт 2	2010 оны 10 сарын 05
Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)	2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-140-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 140 А.6-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг – Ерөнхий зүйл	5
140.1. Хамрах хүрээ	5
140.3. Тодорхойлолт	5
140.5. Гэрчилгээжих шаардлага	6
140.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт	6
140.9. Гэрчилгээ олгох	6
140.11. Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон чиг үүрэг	6
140.13. Гэрчилгээний хугацаа	7
140.15. Гэрчилгээ сунгах.....	7
В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	8
140.51. Ажилтанд тавих шаардлага	8
140.53. Үйл ажиллагааны журам тогтоох.....	8
140.55. Баримт бичиг	9
140.57. Бүртгэл.....	9
140.59. Дотоод чанар баталгаажуулалт	10
140.61. Байгууллагын Ерөнхий заавар	11
С Бүлэг – Үйл ажиллагааны шаардлага	13
140.101. Байнгын хэрэгжүүлэлт	13
140.103. Ерөнхий зааврын өөрчлөлт	13
Хавсралт А – Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт	15
A.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах	15
A.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хяналт.....	15
A.3. Агаарын хөлгийг шалгах	15
A.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон тоног төхөөрөмж.....	16
A.5. Хүнд аюулгүйн үзлэг хийх.....	17
A.6. Рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийх.....	17
A.7. Гар тээшийг гараар шалгах	18
A.9. Аюулгүйн үзлэг хийгдэж буй этгээдэд тавих хяналт	19
A.10. Аюулгүйн үзлэгийг зөрчих.....	19
A.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөл – арга хэмжээний төлөвлөгөө болон дохио.....	19
A.12. Хөдөлгөөнт эргүүл.....	20
A.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүй байдал.....	22
A.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэт сонгох үзлэг	22
A.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж баталгаажуулах	22
A.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдагч	23
A.17. Явган эргүүл	23
A.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт.....	23
A.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл.....	24
A.20. Нууцлал болон мэдээлэл	24
A.21. Бусад байгууллагатай харилцах	25
A.22. НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага	25
A.23. Сургалт.....	25
A.24. Давтан сорилт хийх.....	27
A.25. Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс	30

А Бүлэг – Ерөнхий зүйл

140.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

140.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

Аюулгүйн хамгаалалтын менежмент гэж 140.61(a)(5)-д заасан байрлал бүрийг хариуцсан нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтныг, үүнд тухайн ажилтны орлогч, болон тухайн ажилтан хариуцлагаа шилжүүлсэн бусад ажилтан багтана;

Аюулгүйн үзлэгийн цэг гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ИНД-139.203(d)(4)-ийн дагуу, зорчигчийн аюулгүйн үзлэгт зориулан гаргасан талбайг;

Аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламж гэж тухайн цаг хугацаанд аюулгүйн хамгаалалт тогтоосон навигацийн байгууламжийг;

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн үзлэгийн цэг гэж аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ИНД-139.203(d)(4A)-ийн дагуу, аюулгүйн үзлэг болон шалгалт хийгдэх өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн цэгт аюулгүйн үзлэг болон шалгалт хийхэд зориулан гаргасан талбайг;

Зөвшөөрөгдөөгүй эд зүйл гэж эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүй, эсхүл агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлгүй, эсхүл эдгээрийн аль нэгээс нь тухайн зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй аливаа агаарын хөлгийн бүхээгт авч орсон, эсхүл авч орохыг завдсан дараах эд зүйлийг:

- (1) аливаа галт зэвсэг; эсхүл
- (2) аливаа бусад аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл эдгээрийн аливаа төрлийн хэрэгсэл; эсхүл
- (3) аливаа сум хэрэгсэл; эсхүл
- (4) аливаа тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл аливаа бусад гэмтэл учруулах бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглах аливаа төрлийн хэрэгсэл;

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтан гэж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн үндсэн ажилтан, эсхүл тухайн цаг хугацаанд нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтны үүрэг гүйцэтгэж буй этгээдийг;

Өндөр эрсдэлтэй нислэг гэж ердийн заналхийллийн хүчин зүйлээс илүү өндөр нөлөөнд өртөнө гэж дараах этгээд үнэлж, тогтоосон нислэгийг;

- (1) Дарга; эсхүл
- (2) агаарын тээвэрлэгч; эсхүл
- (3) тухайн агаарын хөлгийг Бүртгэгч улс;

Энгийн нислэг гэж өндөр эрсдэлтэй нислэгээс бусад нислэгийг.

140.5. Гэрчилгээжих шаардлага

Аливаа этгээд, энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлөөс гадуур, аюулгүйн хамгаалалттай эродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхгүй.

140.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24140/01 маягыг бөглөн, дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлнэ:

- (1) 140.61-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) зохих төлбөрийн баримт.

140.9. Гэрчилгээ олгох

Дарга, дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ олгоно, хэрэв:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн 140.51-д шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн бол;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь:
 - (i) хамгаалалтын үйлчилгээний байгууллага бол; эсхүл
 - (ii) хамгаалалттай аэродром, эсхүл хамгаалалттай навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аэродром, эсхүл навигацийн байгууламжид нисэхийн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол;
- (3) тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь В Бүлгийн шаардлага хангасан бол;
- (4) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд харшлахгүй бол.

140.11. Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон чиг үүрэг

(а) Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага (цаашид НАХҮБ гэх)-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа заасан байрлал бүрд дараах үйл ажиллагаа болон чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- (1) аюулгүйн хамгаалалттай аэродромд дараах үүргийг гүйцэтгэх:

- (i) бүх олон улсын агаарын хөлгийн зорчигч үйлчилгээний нислэгийн зорчигч, хөлгийн баг, тээшинд аюулгүйн үзлэг хийх болон орон нутгийн агаарын хөлгийн зорчигч үйлчилгээнд, эсхүл бусад үйлчилгээнд Даргын шаардсан аюулгүйн үзлэг хийх;
 - (ii) шаардлагатай бол, агаарын хөлгийг шалгах;
 - (iii) аэродромын аюулгүйн эргүүл хийх;
 - (iv) Даргын шаардсан, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд байгаа, эсхүл нэвтрэх гэж буй аливаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд Даргаар батлагдсан байх ёстой аюулгүйн үзлэгийн тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг болон шалгалт хийх;
- (2) хамгаалалттай навигацийн байгууламжид эргүүл хийх;
- (3) иргэний нисэх болон түүнд ажиллагсад, эсхүл түүний үйлчилгээг авдаг хүмүүсийг хамгаалахтай холбоотой аюулгүйн хамгаалалтын арга техник, тогтолцоо, хэрэгсэл, практик дадал болон журмыг хянах, судлах болон түүний талаар тогтмол мэдээлэлтэй байх;
- (4) энэ Дүрмийн дагуу, өөрийн аливаа ажил үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор цагдаа, төрийн байгууллагууд, нисэх буудлын эрх бүхий байгууллага, үйл ажиллагаа эрхлэгчид болон бусад улсын нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ хариуцсан эрх бүхий байгууллага болон аливаа холбогдох олон улсын байгууллагатай хамтран ажиллах.
- (b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, НАХҮБ нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрт заасан үйл ажиллагаа болон чиг үүргийг хэрэгжүүлнэ.

140.13. Гэрчилгээний хугацаа

- (a) НАХҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) НАХҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.
- (c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүйд тооцсон тохиолдолд гэрчилгээг Даргад хураалгана.
- (d) НАХҮБ-ын гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад хүргүүлнэ.

140.15. Гэрчилгээ сунгах

- (a) НАХҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг гэрчилгээ эзэмшигч нь САА24140/01 маягтын дагуу гаргаж Даргад хүргүүлнэ.
- (b) Тухайн хүсэлтийг, гэрчилгээнд заасан хугацаанд, хэрэв сунгах хугацаа заагаагүй бол, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

140.51. Ажилтанд тавих шаардлага

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар авч ажиллуулна:

- (1) тухайн байгууллагын гүйцэтгэж буй бүх үйл ажиллагааг энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу санхүүжүүлэх болон гүйцэтгэж чадахыг бататгах, хүсэлт гаргагчийн байгууллагын эрх бүхий, гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;
- (2) дараах удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд:
 - (i) тухайн хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах;
 - (ii) гүйцэтгэх захиралд шууд захирагдах;
- (3) 140.61(а)(7)-д дэлгэрэнгүй заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх, шалгах, хянах болон гүйцэтгэх хангалттай тооны ажилтан.

(b) Хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн ажил үүрэг гүйцэтгэхээр хүсэлт гаргасан этгээд бүрийн ур чадварт суурь үнэлгээ хийх журам болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтан (цаашид НАХ-ын ажилтан гэх)-ы ажлын байрны шаардлагыг тухайн этгээдийн:
 - (i) боловсрол;
 - (ii) харилцааны чадвар;
 - (iii) зан харьцаа;
 - (iv) дадлага туршлага;
 - (v) эрүүл мэндийг харгалзан тогтооно;
- (2) түүний ажилтнуудаас, НАХ-ын ажилтан болох этгээдийг томилно;
- (3) түүний НАХ-ын ажилтныг сургах болон ур чадварыг хадгалах журмыг тогтооно;
- (4) 140.61(а)(7)-д дэлгэрэнгүй заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх, шалгах, хянах болон гүйцэтгэхийг зөвшөөрсөн ажилтнуудад, тэдний зөвшөөрлийн хүрээг бичгээр тодорхойлсон нотлох баримт олгоно.

140.53. Үйл ажиллагааны журам тогтоох

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюулгүйн хамгаалалттай аэродромд хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол Хавсралт А-д заасан шаардлагыг хангахад шаардлагатай журмыг тогтооно.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжид хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол А.12 (d)-д заасан шаардлагыг хэрэгжүүлэх журмыг тогтооно.

140.55. Баримт бичиг

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг дэмжихэд хэрэгтэй бүх баримт бичгээр, тухайн баримт бичгийг хэрэглэх шаардлагатай ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ авч ашиглахад боломжтой хэлбэрээр хангадаг болохыг бататгах журмыг тогтооно.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан баримт бичиг нь дараах зүйлийг агуулсан байна:

- (1) холбогдох бүх хууль тогтоомж;
- (2) нисэхийн аюулгүйн холбогдолтой бүх олон улсын техникийн заавар, эсхүл мэдэгдэл;
- (3) Даргаас гэрчилгээ эзэмшигчид олгосон баримт бичиг;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар.

(c) Хүсэлт гаргагч нь, энэ зүйлийн (a)-д заасан дараах үйл ажиллагааг бататгах баримт бичгийг хянах журамтай байна:

- (1) тухайн баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж баталсныг;
- (2) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувь нь, ажилтнууд тухайн баримт бичгийг ашиглахад хэрэгтэй байрлал бүрд бэлэн байхыг;
- (3) хугацаа нь дууссан баримт бичгийг гаргах, эсхүл ашиглах бүх цэгээс нэн даруй хурааж авдаг болохыг;
- (4) баримт бичигт орсон өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, баталсныг;
- (5) баримт бичиг бүрийн хүчинтэй хувь нь танигддаг байхыг;
- (6) байгууллагын Ерөнхий заавар нь, тухайн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйлчилгээ, журам болон байгууламжийн хүчинтэй тодорхойлолтыг хэвээр хадгалж байхаар өөрчилснийг.

(d) Хүсэлт гаргагч нь 140.61-ийн (a)(5)-д заасан байрлал бүрд Ерөнхий зааврын хувийг байлгаж, хөтлөх журмыг тогтоосон байна.

140.57. Бүртгэл

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн нийцлийг бататгахад хэрэгтэй бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх журмыг тогтооно.

(b) Хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтооно:

- (1) түүний НАХ-ын ажилтны туршлага, мэргэшил, ур чадвар, сургалт, эрүүл мэндийн үнэлгээ болон хүчинтэй зөвшөөрлийн дэлгэрэнгүйг багтаасан бүртгэл хөтлөх;

(2) дараах шаардлагыг хангасныг бататгах:

- (i) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын хувиршгүй хэлбэртэй болохыг;
- (ii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсан бүртгэлийг, гэрчилгээ эзэмшигч тухайн этгээдэд олгосон эрхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг болохыг;
- (iii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсанаас бусад бүртгэлийг 2 жилийн хугацаанд хадгалдаг болохыг.

140.59. Дотоод чанар баталгаажуулалт

(a) НАХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмээр шаардсан журмын хэрэгжилт болон тохирлыг бататгах дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаана:

- (1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилго болон түүний үйлчлүүлэгчийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээнд тохирсон аюулгүйн бодлого болон аюулгүйн бодлогын журам;
- (2) тухайн тогтолцоонд оршиж байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдгийг бататгах журам;
- (3) тухайн тогтолцоонд тогтоогдсон хүндрэлтэй асуудлыг засаж залруулсныг бататгах залруулах арга хэмжээний журам;
- (4) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг арилгасныг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
- (5) хүсэлт гаргагчийн байгууллага нь өөрийн Ерөнхий зааварт тусгасан журамтай нийцэж байгаа болон аюулгүйн бодлогод тусгасан зорилтод хүрснийг шалгах, чанарын дотоод аудитын хөтөлбөр;
- (6) хэрэв хамааралтай бол, статистикийн дүн шинжилгээний ашиглалтыг багтаасан, тухайн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ Дүрмийн тухайн шаардлагыг хангаж байгааг бататгах удирдлагын үнэлгээний журам;
- (7) дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар гүйцэтгэх захиралд шууд хандах эрхтэй болохыг бататгах журам.

(c) Аюулгүйн бодлогын журам нь, тухайн аюулгүйн бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг болон мөрддөг болохыг бататгана.

(d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлсон байна:

- (1) оршиж буй хүндрэлтэй асуудлыг залруулах;

- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор залруулах арга хэмжээг эргэн шалгах;
- (3) удирдлага, аливаа залруулах арга хэмжээний үр дүнг үнэлэх.
- (е) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам нь дараах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлсон байна:
- (1) болзошгүй хүндрэлтэй асуудлыг залруулах;
- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн шалгах;
- (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд, энэ Дүрмийн дагуу шаардсан аливаа журамд өөрчлөлт оруулах;
- (4) удирдлага, аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх.
- (f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь:
- (1) аудит хийгдэх ажиллагааны шинж чанартай уялдуулан аудитын давтамж болон байрлалыг заана;
- (2) аудитыг сургалтад хамрагдсан, тухайн аудит хийгдэж буй ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэг этгээдээс хамааралгүй ажилтан хийдгийг бататгана;
- (3) аудитын үр дүнг, аудит хийсэн ажиллагааг хариуцсан ажилтанд болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгана;
- (4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийсэн тухайн ажиллагааг хариуцсан ажилтнаас залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг шаарддаг байна;
- (5) авч хэрэгжүүлсэн залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үнэлгээ хийх зорилгоор эргэн шалгах аудит хийдгийг бататгана.
- (g) Удирдлагын үнэлгээ хийх журам нь:
- (1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг авч үзсэний үндсэн дээр, чанар баталгаажуулалтын тогтолцооны удирдлагын үнэлгээний давтамжийг тодорхойлно;
- (2) тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд үнэлгээ хийх менежерийг тогтооно;
- (3) тухайн үнэлгээний үр дүнг тооцон дүгнэж, бүртгэдэг болохыг бататгана.

140.61. Байгууллагын Ерөнхий заавар

- (a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:
- (1) Ерөнхий заавар нь дараах шаардлагыг багтаасныг бататган, байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
- (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжүүлэлтийг бататгах арга, аргачлалыг харуулах;

- (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрдөхийг;
 - (2) 140.51(а)(1) болон (2)-т шаардсан этгээдүүдийн нэр болон албан тушаал;
 - (3) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харьцах асуудлуудыг багтаасан, энэ зүйлийн (а)(2)-т заасан этгээдийн үүрэг, хариуцлага;
 - (4) энэ зүйлийн (а)(2)-т заасан этгээд болон хяналтын ажилтны хариуцлагын хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
 - (5) тухайн байгууллагын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр зорьж байгаа бүх байрлал болон байрлал бүр дэх байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (6) энэ зүйлийн (а)(5)-д заасан байрлал бүрд шаардлагатай, тухайн байгууллагын ажиллагсдын бүтцийн хураангуй;
 - (7) байрлал бүрд үзүүлэх нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (8) эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтийн хамрах хүрээ болон Хавсралт А.22-т шаардсан бие бялдрын үнэлгээний аргын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (9) дараах зүйлээр шаардсан, хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй:
 - (i) 140.53 - үйл ажиллагааны журмын талаар;
 - (ii) 140.55 - нисэхийн аюулгүйн хамгаалалтын баримт бичгийн хяналт болон түгээлтийн талаар;
 - (iii) 140.57 - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх талаар;
 - (iv) 140.59 - байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын талаар.
 - (10) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт хийх болон түгээх журам;
 - (11) ИНД-12-ын дагуу Даргад аливаа аюулгүйн зөрчлийг мэдэгдэх, шинжлэн шалгах болон мэдээлэх журам;
 - (12) аюултай барааны илрүүлэлтийг Даргад мэдээлэх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг – Үйл ажиллагааны шаардлага

140.101. Байнгын хэрэгжүүлэлт

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) Ерөнхий зааварт заасан ажлын байрлал тус бүрд, Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг байнга хадгална;
- (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог байнга дагаж мөрдөнө;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгүүдийг шаардлагатай ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ байнга ашиглах боломжтой байлгана;
- (4) дараах шаардлага болон стандартыг байнга хангана:
 - (i) В Бүлгийн шаардлага;
 - (ii) 140.53-ын дагуу журамтай байхыг шаардсан Хавсралт А-ийн заалтууд.

140.103. Ерөнхий зааврын өөрчлөлт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг, байгууллагын хүчинтэй тодорхойлолтыг хэвээр хадгалж байхаар хийснийг бататгана;
- (2) Ерөнхий зааварт оруулсон аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгана;
- (3) Ерөнхий зааварт тусгасан нэмэлт өөрчлөлтийн журмыг мөрдөнө;
- (4) Ерөнхий заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлнэ;
- (5) нисэхийн аюулгүйн ашиг сонирхолд анхаарах шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий заавартаа оруулна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах аль нэг өөрчлөлтийг хийх бол Даргаас урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай:

- (1) гүйцэтгэх захирлыг;
- (2) нэр заасан удирдах ажилтныг;
- (3) нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байрлалыг;
- (4) гэрчилгээнд заасан үйл ажиллагааны цар хүрээг;
- (5) байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлтийг хийх хүсэлтийг САА24140/01 маягтын дагуу гаргана.

(d) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлтийн үед, эсхүл өөрчлөлтийн дараа мөрдөх нөхцөлийг тогтоож болно.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-гийн дагуу тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөнө.

(f) Энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлт нь тухайн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байвал, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг Даргад аль болох хурдан хүргүүлнэ.

Хавсралт А – Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

А.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) түүний НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүс бүрийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах зорилгоор, дараах нөхцөл байдалд үзлэгийн дараах бүсэд шалгалт хийдэг болохыг бататгана:
 - (i) зорчигчийн аюулгүйн үзлэг эхлэхээс өмнө;
 - (ii) тухайн бүсийн хамгаалалтын хяналт алдагдсан байж болзошгүй үед.
- (2) түүний НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсэд шалгалт хийхдээ:
 - (i) үзлэгийн дараах бүсэд ямар нэгэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл орхиогүй, эсхүл нуугаагүйг шалгадаг болохыг бататгана;
 - (ii) аюулгүйн үзлэгт хамрагдсан бүх этгээдийг, аюулгүйн үзлэгт хамрагдаагүй этгээдээс тусгаарласныг шалгадаг болохыг бататгана.
- (3) дараах сорилт, эсхүл шалгалт хийдэг болохыг бататгана:
 - (i) үзлэгийн дараах бүсийн аливаа шалгалтын үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд;
 - (ii) үзлэгийн дараах бүсийн аливаа шалгалтыг гүйцэтгэж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг бататгах зорилгоор А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд.

А.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хяналт

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлийг бататгана:

- (1) зөвшөөрөгдөөгүй эд зүйл аливаа агаарын хөлөгт нэвтрээгүй болохыг бататгах зорилгоор зорчигчоос бусад этгээд үзлэгийн дараах бүсэд авч орох, эсхүл хүргэх бүх бараа болон хангамжийн зүйлийг аюулгүйн үзлэг, эсхүл аюулгүйн хяналтад хамруулдаг болохыг;
- (2) түүний НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсийн бүрэн бүтэн байдал алдагдаагүйг бататгах зорилгоор үзлэгийн дараах бүс доторхи хөдөлгөөнд хяналт тавьдаг болохыг.

А.3. Агаарын хөлгийг шалгах

(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан агаарын хөлгийн шалгалтыг хийх үед тухайн шалгалтад:

- (1) өмнө үйлчлүүлсэн зорчигчийн нэвтэрсэн байж болох бусад хэсэг болон зорчигчийн суудал, суудлын дээрх тээшний тасалгаа, шалны талбай, бие засах газрыг хамруулсныг;
- (2) агаарын хөлөгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэх хангалттай хүчин чармайлт гаргасныг бататгана.

(b) Тухайн нислэгийг өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн бол гэрчилгээ эзэмшигч дараах зүйлийг бататгана:

- (1) түүний НАХ-ын ажилтнууд нь үйл ажиллагаа эрхлэгчийн тусламжтайгаар тухайн агаарын хөлгийг бүрэн гүйцэд шалгасныг;
- (2) тухайн шалгалтыг, үйл ажиллагаа эрхлэгчийн тухайн агаарын хөлөгт зориулсан шалгах хуудсыг ашиглан, төлөвлөсөн хэлбэрээр гүйцэтгэснийг;
- (3) тухайн шалгалтад, агаарын хөлөгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэх хангалттай хүчин чармайлт гаргасныг.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) энэ зүйлийн (a), эсхүл (b)-ийн дагуу хийсэн шалгалт бүрийн хувьд, дараах мэдээллийг багтаасан бүртгэл хөтөлснийг бататгана:
 - (i) тухайн шалгалтыг хийсэн ажилтны нэр;
 - (ii) илрүүлсэн аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйлс;
 - (iii) гүйцэтгэсэн аливаа аюулгүй болгох арга хэмжээ.
- (2) дараах сорилт, эсхүл шалгалтыг хийнэ:
 - (i) шалгасан байхыг шаардсан аливаа агаарын хөлгийн шалгалтын үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд;
 - (ii) аюулгүйн үзлэг хийгдээгүй, эсхүл өндөр эрсдэлтэй агаарын хөлгийн шалгалт хийж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг бататгах зорилгоор А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд.

А.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон тоног төхөөрөмж

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үйл ажиллагааг бататгана:

- (1) тухайн аюулгүйн үзлэгийн цэг нь, аюулгүйн хяналтгүй аливаа бүсээс үзлэгийн дараах бүсэд нэвтрэх бүх этгээд түүгээр заавал дамжин өнгөрдөг байхаар байрласныг;
- (2) тухайн агаарын хөлгийн явах нислэгийг шалтгаангүйгээр саатуулахгүй байх стандарт хурдаар аюулгүйн үзлэгийг гүйцэтгэх хангалттай тооны ажилтан болон тоног төхөөрөмжтэй болохыг;
- (3) агаарын хөлөгт тээвэрлэхэд тохиромжтой байдлаар ачсан эд зүйлийг, бүртгэгдсэн тээш хэлбэрээр тээвэрлүүлэхээр хариуцсан агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгснийг;
- (4) түүний НАХ-ын ажилтан нь стандарт сорилын биет ашиглан тухайн аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмжийг чадварлагаар шалгаж чадахыг бататгах зааварчилгаа авсныг;
- (5) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж буй аливаа метал илрүүлэгчид:

- (i) зорчигчийн аюулгүйн үзлэг эхлэхээс өмнө Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандарт сорилын биетээр сорилт хийсэн болохыг;
 - (ii) зөвхөн тухайн стандарт сорилын биетийг мэдрэн зөв ажилласан нөхцөлд ашигладаг болохыг.
- (6) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж буй аливаа рентген төхөөрөмжид Даргын хүлээн зөвшөөрөхүйц аргачлалаар сорилт хийсэн болохыг.

A.5. Хүнд аюулгүйн үзлэг хийх

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн үзлэгийн цэг бүрт, бүх хүмүүс аюулгүйн үзлэгээр орохыг анхааруулсан дараах мэдэгдлийг байрлуулна:

- (1) зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр түүнд, эсхүл түүний тээшинд аюулгүйн үзлэг хийдэг болохыг;
- (2) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан аливаа этгээдийг тухайн цэгээс цааш нэвтрүүлэхээс татгалздаг болохыг;
- (3) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан аливаа зорчигчийг агаарын тээвэрлэгч тээвэрлэхээс татгалздаг байх үүрэгтэй болохыг.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) түүний НАХ-ын ажилтан, аливаа этгээдэд аюулгүйн үзлэг хийгээгүй тохиолдолд, тухайн этгээдийг аюулгүйн үзлэгийн цэгээр дамжин үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана;
- (2) хэрэв тухайн этгээдийг Засгийн газраас тусгайлан чөлөөлснөөс бусад тохиолдолд, түүний НАХ-ын ажилтан тухайн зорчигч, эсхүл багийн гишүүнд аюулгүйн үзлэг хийхгүйгээр, аливаа явж буй зорчигч, эсхүл багийн гишүүнийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана;
- (3) түүний НАХ-ын ажилтан нь аливаа этгээдэд аюулгүйн үзлэг хийхдээ, тухайн этгээд аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч яваа болохыг, эсхүл тээвэрлээгүйг шалгадаг болохыг бататгана;
- (4) дараах сорилт, эсхүл шалгалт хийнэ:
 - (i) аливаа аюулгүйн үзлэгийн үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд;
 - (ii) аюулгүйн үзлэг хийж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг бататгах зорилгоор А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд.

A.6. Рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийх

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь түүний НАХ-ын ажилтан аливаа эд зүйлд рентген төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг хийхдээ:

- (1) тухайн зүйлд аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт өөртөө итгэлтэй байхыг;

(2) рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр гарсан дүрсийг 10 минутаас дээш хугацаагаар тасралтгүй ажиглахгүй байхыг бататгана.

(b) Аливаа эд зүйл өөр эд зүйлд агуулагдсаны улмаас зөвшөөрөгдөөгүй эд зүйл биш болох нь рентген төхөөрөмжийн шалгалтаар үнэн зөв танигдахгүй байгаа, эсхүл ямар нэг эргэлзээ байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь түүний НАХ-ын ажилтан тухайн эд зүйлийг зөв таних хүртэл тухайн эд зүйлийг, эсхүл авч яваа тухайн этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана.

(c) Гэрчилгээ эзэмшигч, дараах сорилт, эсхүл шалгалт хийнэ:

(1) аливаа рентген төхөөрөмжийн аюулгүйн үзлэгийн үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд;

(2) рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг бататгах зорилгоор А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд.

А.7. Гар тээшийг гараар шалгах

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

(1) түүний НАХ-ын ажилтан нь гар тээшинд гараар үзлэг хийхдээ, тухайн зүйлд ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт өөртөө итгэлтэй байхыг;

(2) түүний НАХ-ын ажилтан нь гар тээшинд ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй болсноос бусад тохиолдолд, тухайн тээшийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглодог ба тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгддэг болохыг;

(3) хэрэв аливаа эд зүйлд тэсрэх бодис агуулсныг сэжиглэх шалтгаан байвал, түүний НАХ-ын ажилтан нь А.11(b)(5)-д шаардсан журмыг мөрддөг болохыг бататгана.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь, зорчигч компьютер, видео камер, эсхүл ижил төстэй эд зүйлээ рентген төхөөрөмжөөр шалгуулахаас татгалзсан тохиолдолд, түүний НАХ-ын ажилтан дараах ажиллагааг хийх хүртэл тухайн эд зүйл болон түүнийг авч яваа этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгана:

(1) хэрэв боломжтой бол, тухайн эд зүйлийг гараар шалгах ба зорчигчоос тухайн төхөөрөмжийг ажиллуулахыг шаардана;

(2) хэрэв гараар шалгах боломжгүй бол, тухайн эд зүйлийг дараах шаардлагуудыг бүрэн хангасан тохиолдолд бүхээгт авч орохыг зөвшөөрч болно:

(i) тухайн эд зүйл нь хэвийн ажиллаж байгаа бол;

(ii) тухайн эд зүйлийн харагдах байдал нь шинэ, эсхүл шинэвтэр бол;

(iii) тухайн хайрцаг гэрний эрэг шургийн гэмтлийг багтаасан, гэмтэл учруулсан, эсхүл өөрчилсөн шинж тэмдэггүй бол;

- (iv) тухайн зорчигчийн төлөв байдалд аливаа эргэлзээ төрүүлэх шалтгаан ажиглагдаагүй бол;
 - (v) тухайн эд зүйл, эсхүл түүний агууламжийн хувьд, эргэлзээ төрүүлэх бусад шалтгаан байхгүй бол.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь дараах сорилт, эсхүл шалгалт хийнэ:
- (1) аливаа гар шалгалтын үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд;
 - (2) гар шалгалт хийж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг бататгах зорилгоор А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд.

А.9. Аюулгүйн үзлэг хийгдэж буй этгээдэд тавих хяналт

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь:

- (1) рентген төхөөрөмжид эд зүйлийг ачаалдаг бол:
 - (i) аливаа эргэлзээ төрүүлж байгаа этгээдийн талаар анхааруулах дохио өгдөг болохыг;
 - (ii) авч яваа эд зүйлийг тавцан дээр, рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг шалгалт хийхэд түүний НАХ-ын ажилтанд хялбар байдлаар байрлуулдаг болохыг бататгана;
- (2) гар метал илрүүлэгчээр ажилладаг бол, метал илрүүлэгч хаалга нь дохио өгсөн эсэхээс үл хамааран эргэлзээ төрүүлж байгаа бүх этгээдэд аюулгүйн үзлэг хийдэг болохыг бататгана.

А.10. Аюулгүйн үзлэгийг зөрчих

(a) Аюулгүйн үзлэг хийгдсэн зорчигч үзлэгийн дараах бүсэд зөвшөөрөлгүй аюулгүйн үзлэг хийгдээгүй этгээдтэй харьцсан бол, НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь:

- (1) тухайн үзлэгийн дараах бүсээс бүх хүмүүсийг гаргадаг болохыг;
- (2) тухайн үзлэгийн дараах бүсэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл үлдээгүйг бататгах зорилгоор үзлэгийн дараах бүсэд давтан шалгалт хийдэг болохыг;
- (3) А.5(b)-ийн дагуу тухайн үзлэгийн дараах бүсэд нэвтэрч буй бүх хүмүүсийг аюулгүйн үзлэгт давтан хамруулдаг болохыг бататгана.

(b) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт аливаа зөвшөөрөгдөөгүй этгээд илэрвэл, аюулгүйн үзлэг хийгдсэн болон хийгдээгүй хүмүүс холилдоогүй байсан ч, энэ нь тухайн эрсдэлтэй бүсэд шалгалт хийх хангалттай нөхцөл болно.

А.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөл – арга хэмжээний төлөвлөгөө болон дохио

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, аливаа этгээдийн аюулгүй байдал алдагдсан, эсхүл алдагдсан байж болох нөхцөл үүссэн тохиолдолд, аюулгүйн үзлэгийн цэг бүрд

болон хамаарал бүхий өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн аюулгүйн үзлэгийн цэг бүрд тухайн нөхцөл байдлыг зохицуулах журмыг тогтооно.

(b) Аюулгүйн үзлэгийн цэг бүрийн хувьд, гэрчилгээ эзэмшигч нь өөрийн журамд дараах журмыг багтаасан байна:

- (1) аюулгүйн үзлэгийн цэг тус бүрийн, тухайн байрлалтай холбоотой нүүлгэн шилжүүлэх журмыг;
- (2) онцгой нөхцөл бий болсныг бусад НАХ-ын ажилтанд анхааруулах журмыг;
- (3) түүний НАХ-ын ажилтан нь аюулгүйн үзлэгийн цэг бүрд дараах нууц дохио ажиллуулах журмыг:
 - (i) өөрийн аюулгүйн алба болон Цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
 - (ii) онцгой нөхцөл үүссэн үед 139.57-д шаардсан Аэродромын Онцгой байдлын төлөвлөгөөний шаардлагын дагуу холбогдох бусад газарт мэдэгдэх;
- (4) дараах тохиолдолд авах арга хэмжээ:
 - (i) тухайн этгээдээс аюулгүйн үзлэгийн цэгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл илэрсэн ба этгээд нь гэмт хэргийн зорилготой байж болох нөхцөл байдалд;
 - (ii) тухайн рентген төхөөрөмжийн дэлгэцээр зөвшөөрөгдөөгүй эд зүйл танигдсан тохиолдолд, түүний НАХ-ын ажилтан тухайн зорчигчийг сэжигтэй эд зүйлээс нь тусгаарлах оролдлого хийдэг болохыг бататгах;
- (5) сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн үед авах, дараах арга хэмжээний журам:
 - (i) Цагдаагийн байгууллага болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэх;
 - (ii) аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;
 - (iii) тухайн бүсийг чөлөөлөхөд нь туслах;
 - (iv) тухайн зөрчил гаргагчийг илрүүлэх болон саатуулахад нь Цагдаагийн байгууллагад туслах.

(c) Энэ зүйлийн (a)-д заасан журамтай өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн аюулгүйн үзлэгийн цэг бүрийн хувьд, гэрчилгээ эзэмшигч нь хэрэв хамааралтай бол, энэ зүйлийн (b)-д заагдсан аливаа эд зүйлийг тухайн журамд оруулах үүрэгтэй.

A.12. Хөдөлгөөнт эргүүл

(a) Энэ зүйлийн (c), эсхүл (d)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь дараах зорилгоор хоногт 24 цагийн турш хөдөлгөөнт эргүүл хийдэг болохыг бататгана:

- (1) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан байрлалуудын үйл ажиллагааны аюулгүй байдалд заналхийлж болох этгээдийг илрүүлэх;

(2) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан байрлалуудын аюулгүй байдалтай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

(b) Гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь хөдөлгөөнт эргүүл хийх үедээ дараах шаардлага хангаж байгааг бататгана:

(1) 140.61(a)(5)-д заасан, гэрчилгээ эзэмшигчийн хариуцлагын бүс дэх байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй болохыг;

(2) энэ зүйлийн (b)(1)-д заасан бүсийг бүрэн хамарч байгааг;

(3) эргүүлийг дараах байдлаар хийдэг болохыг:

(i) тогтмол бус давтамжтай;

(ii) зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл болон хүмүүсийг шалгаж тогтоох;

(iii) тухайн аэродромын аюулгүйн хамгаалалттай, эсхүл өөр хэлбэрээр хориглосон бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэлтийг илрүүлэх.

(4) аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалтын бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн аль нэг хэсэгт аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлийн дуудлага хүлээж аваад 5 минутын дотор тухайн хэсэгт байхыг;

(5) аюулгүйн хамгаалалтын бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс дэх ачааны болон тээвэрлэлтийн талбайд эргүүл хийх;

(6) аэродромын аюулгүйн хамгаалалтын бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс дэх навигацийн байгууламжид эргүүл хийх;

(7) тухайн аэродромын аливаа аюулгүйн хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийг тойрсон хашаа болон хаалт, аюулгүйн хамгаалалтын периметрийн зөрчлийг илрүүлэх зорилгоор шалгах;

(8) энэ зүйлийн (b)(7)-д шаардсан үзлэг нь дараах ажиллагааг багтаасныг бататгах:

(i) тухайн периметрийн хашааг шөнийн цагаар 3-аас доошгүй, өдрийн цагаар 3-аас доошгүй удаа эргэдэг болохыг;

(ii) барилга болон байгууламжид өөр өөр цагт эргүүл хийдэг болохыг;

(iii) аюулгүйн хамгаалалтын бүсийн болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгадаг болохыг;

(iv) шаардсан хүрээг бүрэн хамарсныг бататгах периметрийн үзлэг бүрийн бүртгэлийг хөтөлдөг болохыг.

(c) Тухайн НАХҮБ нь олон улсын нисэх буудлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол, түүний НАХ-ын ажилтан нь дараах тохиолдолд энэ зүйлийн (b)(8)-ийг дагаж мөрдөхгүйгээр, хоногт 24 цагаас доош хугацаагаар тухайн аэродромд хөдөлгөөнт эргүүл хийж болно, хэрэв:

(1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь хоногт 24 цагийн өөрийн аюулгүйн хамгаалалттай бол;

(2) түүний НАХ-ын ажилтан нь олон улсын явах нислэгийн өмнөх 90 минутаас эхлэн, нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.

(d) Гэрчилгээ эзэмшигч, аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч бөгөөд түүний НАХ-ын ажилтан нь дараах зорилгоор эргүүл хийдгийг бататгадаг бол, тухайн байгууламжид хоногт 24 цагаас бага хугацаагаар хөдөлгөөнт эргүүл хийж болно:

- (1) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацийн байгууламжуудын үйл ажиллагааны аюулгүй байдалд заналхийлж болох этгээдийг илрүүлэх;
- (2) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацийн байгууламжуудын аюулгүй байдалтай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

А.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүй байдал

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь:

- (1) аливаа шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж байхдаа:
 - (i) ИНД-19.357-д заасны дагуу, зөвхөн одоогийн хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй этгээдийг шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэхийг зөвшөөрдөг болохыг;
 - (ii) тухайн шалган нэвтрүүлэх цэгийг хяналтгүй орхисон аль ч үед шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүй байдал хангагдсан болохыг бататгана;
- (2) тээврийн хэрэгслийн аюулгүйн шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж байхдаа зөвхөн зөвшөөрөгдсөн этгээд болон тээврийн хэрэгсэл тухайн шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэхийг зөвшөөрдөг болохыг бататгана.

А.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэт сонгох үзлэг

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь дараах аюулгүйн хамгаалалтын гэнэт сонгох үзлэг хийдэг болохыг бататгана:

- (1) аюулгүйн хамгаалалтын бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд байгаа, эсхүл нэвтрэхийг оролдож буй хүмүүсээс сонгож ИНД-19.357-д заасны дагуу тухайн цаг үеийн болон хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй болохыг бататгах;
- (2) тээврийн хэрэгсэл нь аюулгүйн хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд байх зөвшөөрөлтэй болохыг бататгах.

А.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж баталгаажуулах

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч, түүний НАХ-ын ажилтан нь:

- (1) нэвтрэх зорилгоор ашиглагдах нисгэгчийн үнэмлэх болон нэвтрэх үнэмлэхийг хянаж шалгадаг болохыг;
- (2) хэрэв энэ хэсгийн (1)-д заасан баримт бичгийн бодит байдалд аливаа эргэлзээ байвал, тухайн үнэмлэхийг гээгдүүлсэн, эсхүл хулгайлагдсан, эсхүл бусад байдлаар хүчингүй болсон эсэхийг тогтоодог болохыг бататгана.

А.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдагч

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь хүмүүс, эсхүл тээврийн хэрэгслийг НАХ-ын ажилтан дагалддаг байхыг (эскорт) шаардсан журамтай байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь, НАХ-ын ажилтан бүр аюулгүйн хамгаалалтын дагалдагчийн үүрэг гүйцэтгэж эхлэхийн өмнө тухайн дагах этгээдэд дараах зааварчилгаа өгдөг болохыг бататгана:

- (1) хэрэв тухайн этгээд нь тээврийн хэрэгсэлд байгаа бол, дагуулж буй тээврийн хэрэгслийн араас ойрхон дагах;
- (2) дагуулж буй ажилтны өгч буй бүх зааварчилгааг мөрдөх.

(c) Хэрэв тухайн дагаж байгаа этгээд нь аюулгүйн хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд дагуулж байгаа ажилтангүй үлдэх бол, тухайн дагаж байгаа этгээдийг үлдээхийн өмнө ажилтан дараах зааварчилгааг өгнө:

- (1) дагуулж байгаа ажилтны тогтоосон тухайн бүсийг дагуулж байгаа ажилтангүйгээр орхихгүй байх;
- (2) тухайн бүсээс гарахад дагалдагч шаардлагатай бол, гэрчилгээ эзэмшигчтэй хэрхэн холбоо барих талаар.

А.17. Явган эргүүл

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангасныг бататгана:

- (1) түүний НАХ-ын ажилтан нь иргэний нисэхийн аюулгүй байдалд заналхийлж болох этгээдийг илрүүлэх явган эргүүл хийдэг болохыг;
- (2) явган эргүүл хийх түүний НАХ-ын ажилтан нь:
 - (i) хариуцсан бүс дэх байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй болохыг;
 - (ii) хариуцсан бүсийг бүрэн хамарсан эргүүл хийдэг болохыг;
 - (iii) мэдэгдсэн, эсхүл тогтоогдсон аюулгүй байдалтай холбоотой аливаа зөрчилд нэн даруй хариу арга хэмжээ авдаг болохыг.

А.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаж байгааг бататгана:

- (1) тухайн байгууллагын гэрчилгээнд заагдсан аэродромд түүний НАХ-ын ажилтан нь:
 - (i) үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийг байнгын ерөнхий хяналтан дор байлгахыг;
 - (ii) зөвшөөрөгдөөгүй этгээд агаарын хөлөгт ойртох, эсхүл аливаа агаарын хөлгийн бүхээгт нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийг;

- (iii) олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлгийг тойрч үзлэг ажиглалт хийхдээ аливаа этгээд, эсхүл зөвшөөрөгдөөгүй эд зүйл нуусан байж болзошгүй хэсгүүдэд анхаарал хандуулахыг;
 - (2) энэ зүйлийн (b)-д заасныг үл харгалзан, түүний НАХ-ын ажилтан нь олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийн эргүүлийг:
 - (i) тогтмол бус давтамжтай;
 - (ii) шөнийн цагаар, хоёр цаг тутамд 1-ээс доошгүй удаа;
 - (iii) өдрийн цагаар, дөрвөн цаг тутамд 1-ээс доошгүй удаа хийдэг болохыг;
 - (3) түүний НАХ-ын ажилтан нь дараах нөхцөлд агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийг агаарын хөлөгт ирэхийг шаарддаг болохыг:
 - (i) хяналтгүй орхисон агаарын хөлөг, хоолой (air-bridge)-д холбогдсон ба хамгаалалтгүй бол;
 - (ii) тухайн агаарын хөлөг хөндлөнгийн халдлагад өртсөн байж болзошгүй шалтгаан байвал.
- (b) Тухайн НАХҮБ нь олон улсын нисэх буудлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол түүний НАХ-ын ажилтан, тухайн аэродромоос олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлөгт энэ зүйлийн (a)(2)-т шаардсанаас бага хугацаагаар эргүүл хийж болно, хэрэв:
- (1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь хоногт 24 цагийн өөрийн аюулгүйн хамгаалалттай бол;
 - (2) түүний НАХ-ын ажилтан нь явах нислэгийн хуваарьт цагийн өмнөх 90 минутаас эхлэн, нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.

A.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн хамгаалалтын бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд эргүүл хийхэд ашиглах тээврийн хэрэгсэл бүр дараах шаардлагыг хангасныг бататгана:

- (1) аэродромын бусад хэрэглэгчдэд танигдахуйц таних тэмдэгтэй болохыг;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу тоноглогдсон болохыг.

A.20. Нууцлал болон мэдээлэл

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, ангилагдсан баримт бичгийг:

- (1) ангиллаас нь хамааран түгжээтэй сейфэнд, эсхүл шүүгээнд хадгалдаг болохыг;
- (2) зөвхөн “мэдэж байх шаардлагад” үндэслэн, хүлээн авахаар зөвшөөрөгдсөн хувь хүн, эсхүл байгууллагад түгээдэг болохыг бататгана.

А.21. Бусад байгууллагатай харилцах

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, энэ дүрмийн 140.61(a)(5)-д заасан байрлал бүрийн хувьд, дараах үүрэгтэй:

- (1) тухайн байрлалын үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлөх, онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд оролцох бусад бүх байгууллагатай зөвлөлдөх болон хамтарч ажиллах;
- (2) тухайн байрлалд байгаа бусад байгууллагын бүх ажилтны аюулгүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх хангалттай мэдээлэл өгөгдөж байгааг бататгах аюулгүйн хамгаалалтын хороо байгуулах.

(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (a)(2)-ын дагуу байгуулагдсан аюулгүйн хамгаалалтын хороог 12 сард нэгээс доошгүй удаа хуралдуулж, хурлыг удирдах болон аюулгүйн хамгаалалтын хорооны уулзалтын тэмдэглэл хөтлөх үүрэгтэй.

А.22. НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, тухайн этгээд эрүүл мэндийн хувьд, тухайн ажил үүргийг гүйцэтгэх боломжтойг эмнэлгийн үзлэгийн тайланд үндэслэн үнэлгээ хийгдэх хүртэл, аливаа этгээдийг НАХ-ын ажилтны албан тушаалд томилдоггүй болохыг бататгана.

А.23. Сургалт

(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээ эзэмшигчийн ажилтан дараахаас бусад тохиолдолд, НАХ-ын ажилтны үүрэг гүйцэтгэдэггүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тэдний гүйцэтгэх үүрэгт хамаарах, энэ зүйлийн (c)-д заасан сэдвээр сургалтад хамрагдсан;
- (2) сургалтын төгсгөлд бичгийн шалгалт өгсөн;
- (3) хамрагдсан сургалтын сэдэв тус бүрээр, энэ зүйлийн (c)-д заасан ур чадварын түвшинг хангасан.

(b) Энэ зүйлийн (c)-д заасан ур чадварын түвшний үнэлгээний тогтолцоо нь дараах хэлбэртэй байна:

- (1) Үнэлгээ 1- тухайн сэдвийн ойлголтыг харуулна;
- (2) Үнэлгээ 2 - тухайн сэдвийн суурь мэдлэгийг харуулна;
- (3) Үнэлгээ 3 - тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн суурь мэдлэгээ ашиглах чадварыг харуулна;
- (4) Үнэлгээ 4 - тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглаж шийдвэр гаргах чадварыг харуулна;
- (5) Үнэлгээ 5 – тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглан нөхцөл байдлыг зөв тодорхойлж илэрхийлэх чадварыг харуулна.

(с) Энэ зүйлийн (а)-д заасан ажилтны сурсан болон үнэлүүлсэн байхыг шаардсан дараах сэдвүүд:

(1) Нисэхийн аюулгүйн холбогдолтой хууль тогтоомж:

- (i) Үнэлгээ 4-өөр, Эрүүгийн хуульд заасан, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн талаар;
- (ii) Үнэлгээ 3-аар, Хүний эрхийн холбогдолтой хууль тогтоомж болон хувь хүнд нэгжлэг хийх, эсхүл баривчлан саатуулах талаар (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох зүйл);
- (iii) Үнэлгээ 5-аар, Иргэний нисэхийн тухай хуульд заасан НАХ-ын ажилтны эрх, үүрэг болон хариуцлагын талаар;
- (iv) ИНД-108 “Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хөтөлбөр”-ийн талаар;
- (v) Үнэлгээ 3-аар, Зөрчлийн тухай хуулийн талаар;
- (vi) Үнэлгээ 3-аар, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн талаар (Эрүүгийн хуулийн холбогдох зүйл);
- (vii) Үнэлгээ 5-аар, Хүч хэрэглэх болон баривчлах талаар (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох зүйл, заалт);

(2) Зорчигч, тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх:

- (i) Үнэлгээ 4-өөр, зорчигч, тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх зохицуулалтын ерөнхий зарчмын тойм;
- (ii) Үнэлгээ 4-өөр, гэрчилгээ эзэмшигчийн ашигладаг аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмжийг мэддэг, мэргэжлийн ур чадвартай ашигладаг байх;
- (iii) Үнэлгээ 4-өөр, зорчигч, түүний тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх журам болон аргыг хэрэглэх дадлага туршлагатай байх;

(3) Агаарын хөлгийн хорлон сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт - Үнэлгээ 4-өөр: заналхийллийн дараа, агаарын хөлгийн хорлон сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт шаардсан үед хариу үйлдлийг шалгах, эсхүл хэрэв тухайн агаарын хөлөг өмнө нь аюулгүйн үзлэггүйгээр үйлчилгээнд оролцсон бол түүнийг дараагийн нислэгийн өмнөх аюулгүйн үзлэгийн өмнө, аюулгүй болохыг бататгахаар авах арга хэмжээний талаар;

(4) Гар хийцийн тэсрэх төхөөрөмж - Үнэлгээ 3-аар: нисэх буудал, агаарын хөлөг, эсхүл зорчигчийн аюулгүйн үзлэгийн цэгт илэрч болох, иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлдөг гар хийцийн тэсрэх төхөөрөмжийн талаар НАХ-ын ажилтанд ойлголт өгөх;

(5) Зэвсэглэсэн гэмт хэрэгтэнтэй харьцах - Үнэлгээ 3-аар: зэвсэглэсэн гэмт хэрэгтнийг саатуулах болон бусад хүмүүсийг тухайн заналхийллээс хамгаалах арга хэмжээний талаар НАХ-ын ажилтанд зааварчилгаа өгөх;

- (6) **Агаарын хөлөг барьцаалахын эсрэг хариу үйлдлийн журам** - Үнэлгээ 2-оор: онгоц булаах үед мөрдөх журмын талаар НАХ-ын ажилтанд ойлголт өгөх;
- (7) **Явган болон хөдөлгөөнт эргүүл** - Үнэлгээ 4-өөр: урьдчилан сэргийлэх явган болон хөдөлгөөнт эргүүл болон аюулгүйн зөрчлийн хариу үйлдлийн талаарх бүх талын мэдлэгийг НАХ-ын ажилтанд олгох;
- (8) **Аэродром дээрх хөдөлгөөн** - Үнэлгээ 5-аар: аэродром дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нарийвчилсан журмыг НАХ-ын ажилтанд заах;
- (9) **Нисэхийн радио-холбооны үйл ажиллагаа болон журам** - Үнэлгээ 4-өөр: хязгаарлагдмал радио-холбооны операторын гэрчилгээний стандартын дагуу зөв радио-холбооны сахилга батыг сахих талаар НАХ-ын ажилтанд заах;
- (10) **Заналхийллийн хүчин зүйл** - Үнэлгээ 2-оор: алан хядах ажиллагаа болон гэмт хэргийн өнөөгийн хандлагын талаар НАХ-ын ажилтанд шинэчилсэн мэдээлэл өгөх;
- (11) **Зэвсэг** - Үнэлгээ 3-аар: нислэгийн өмнөх аюулгүйн үзлэгийн үеэр галт зэвсэг болон бусад ижил төстэй зэвсэглэлийг таньж тогтооход нь дэмжлэг болох зорилгоор, эдгээр эд зүйлийн талаар НАХ-ын ажилтанд мэдлэг олгох;
- (12) **Хууль бус үйлдлийн түүхэн баримт болон статистик** - Үнэлгээ 2-оор: нисэхийн аюулгүйн түүхэн хөгжил болон хэрэг явдлын тархацын талаар НАХ-ын ажилтанд мэдлэг олгох;
- (13) **Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын талаарх баримт мэдээлэл** - Үнэлгээ 1-ээр: ИКАО, Конвенцийн талаар, Хавсралт 17 болон түүнтэй холбоотой Doc 8973-ын талаар НАХ-ын ажилтанд мэдлэг олгох.

А.24. Давтан сорилт хийх

- (a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь түүний НАХ-ын ажилтнуудад урьдчилан мэдэгдэлгүйгээр, стандарт сорилын биет ашиглан сорилт хийдэг болохыг бататгах үүрэгтэй.
- (b) Сорилтыг, аюулгүйн үзлэгийн үйл ажиллагааны цогц байдалд үнэлгээ өгөх зорилгоор боловсруулах ба соригдож буй түүний НАХ-ын ажилтанд стандарт сорилын биетийг илрүүлэх зохих боломж олгох хэлбэрээр зохион байгуулах ёстой.
- (c) Стандарт сорилын биетийг Даргын хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, давтан сорилтод ашиглахыг хориглоно.
- (d) Стандарт сорилын биет бүр нь:
 - (1) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг төлөөлдөг байх;
 - (2) үйл ажиллагааны бодит нөхцөлд ашигладаг байх ёстой.
- (e) Соригдож буй, эсхүл давтан соригдож буй НАХ-ын ажилтнуудын ур чадварыг тодорхойлохдоо дараах хэмжүүрийг ашиглах ёстой:

- (1) хэрэв сорилтын явцад стандарт сорилын биет бүрийг илрүүлсэн бол, соригдож буй НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаж байна гэж үзнэ;
 - (2) хэрэв энэ зүйлийн (f)-ээс (k)-ийн дагуу хийгдэж буй аливаа сорилтын явцад стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол, соригдож буй НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаагүй гэж үзэн дараах арга хэмжээг авах ёстой:
 - (i) давтан сорилтод хамруулах байх;
 - (ii) давтан сорилтыг амжилттай өгөх хүртэл тухайн үүргийг гүйцэтгүүлэхгүй байх;
 - (3) хэрэв давтан сорилтоор стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол:
 - (i) сорилт хийж буй тухайн шалгагч нь аюулгүйн удирдлагад мэдэгдэх ёстой;
 - (ii) аюулгүйн удирдлага нь тухайн алдааг бүртгэх ёстой;
 - (iii) аюулгүйн удирдлага нь, сорилтод тэнцээгүй түүний НАХ-ын ажилтан бүрийг залруулах давтан сургалтад хамруулах ба ажилтан тухайн ажил үүргийг дахин гүйцэтгэхийг зөвшөөрөхийн өмнө, ажилтан тухайн даалгаврын стандартыг хангаж чадахыг харуулах сорилтод хамруулах ёстой.
- (f) Гэрчилгээ эзэмшигч нь, метал илрүүлэгчийн сорилт хийгдэж байх үед, дараах зүйлийг бататгах үүрэгтэй:
- (1) сорилт хийж буй шалгагч нь стандарт сорилын биетийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилын тээгчид нуусныг;
 - (2) тухайн сорилын тээгч нь:
 - (i) хэрэв тухайн илрүүлэгч нь метал илрүүлэгч-хаалга бол, ердийн алхах хурдаар зорчигчийн урсгалын чиглэлд метал илрүүлэгчээр нэвтрэхийг; эсхүл
 - (ii) тээврийн хэрэгсэлд сууж, эсхүл тээвэрлэгдсэн байдлаар нэвтрэхийг;
 - (3) метал илрүүлэгч-хаалганы дохиолол ажилласан бол, тухайн шалгагч нь соригдож буй НАХ-ын ажилтан гар-метал илрүүлэгч ашиглан, эсхүл биеийн шалгалт хийн стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тодорхойлохыг;
 - (4) гар-метал илрүүлэгчийн дохиолол ажилласан бол, тухайн шалгагч нь соригдож буй НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тодорхойлохыг;
 - (5) хэрэв тухайн стандарт сорилын биет ойртоход метал илрүүлэгч-хаалганы, эсхүл гар-метал илрүүлэгчийн дохиолол ажиллаагүй бол:
 - (i) төхөөрөмжид алдаа байгаа талаар тухайн шалгагч аюулгүйн удирдлагад мэдэгдэхийг;

(ii) үйл ажиллагааны стандартыг хангах хүртэл тухайн метал илрүүлэгчийг үйлчилгээнээс гаргахыг.

(g) Гэрчилгээ эзэмшигч, рентген төхөөрөмжид сорилт хийгдэж байгаа тохиолдолд, сорилт хийж буй шалгагч нь дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж буй цүнх саванд бусад эд зүйлийн хамт байрлуулсныг;
- (2) соригдож буй тухайн НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр таних болон гар шалгалтаар стандарт сорилын биетийг илрүүлж байгаа эсэхийг тодорхойлсныг;
- (3) тухайн агууламж нь рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр зөв танигдахааргүй байгаа бол, гар шалгалт хийх шаардлагыг зөв тодорхойлох НАХ-ын ажилтны чадварыг үнэлж тогтоосныг.

(h) Гэрчилгээ эзэмшигч, гар шалгалтын сорилт хийгдэж байгаа бол, сорилт хийж буй шалгагч нь дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж буй цүнх саванд бусад эд зүйлийн дунд нуусныг;
- (2) соригдож буй тухайн НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тодорхойлсныг.

(i) Гэрчилгээ эзэмшигч, үзлэгийн дараах бүсэд сорилт хийгдэж байгаа бол, сорилт хийж буй шалгагч нь дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) үзлэгийн дараах бүсийг шалгах аас өмнө стандарт сорилын биетийг тухайн бүсэд нуусныг;
- (2) НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тодорхойлсныг.

(j) Гэрчилгээ эзэмшигч, агаарын хөлгийг шалгах сорилт хийгдэж байгаа бол, сорилт хийж буй шалгагч нь дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) зорчигч хэвийн байдлаар нэвтэрч болох тухайн агаарын хөлгийн аливаа хэсэгт стандарт сорилын биетийг нуусныг;
- (2) НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тодорхойлсныг.

(k) Гэрчилгээ эзэмшигч, тээврийн хэрэгслийн шалгалтын сорилт хийгдэж байгаа бол, тухайн шалгагч нь дараах ажиллагааг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн тээврийн хэрэгслийн аль нэг хэсэгт стандарт сорилын биетийг нуусныг;
- (2) НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тодорхойлсныг.

А.25. Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс**Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн үзлэгийн цэг болон тоног төхөөрөмж**

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангаж байгааг бататгах үүрэгтэй:
- (1) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс рүү нэвтэрч буй, эсхүл тухайн бүс дотор байгаа хүмүүс, эд зүйлс, бодис болон тээврийн хэрэгсэлд Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг, эсхүл шалгалт хийдэг болохыг;
 - (2) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс рүү нэвтэрч буй, эсхүл тухайн бүс дотор байгаа хүмүүст, тэдэнтэй холбоотой эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийг оролцуулан аюулгүйн үзлэг, эсхүл шалгалт хийхдээ Сайдын, эсхүл Даргын шаардсаны дагуу хийдэг болохыг;
 - (3) Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг болон шалгалтыг хийх хангалттай тооны ажилтан болон тоног төхөөрөмжтэй болохыг;
 - (4) түүний НАХ-ын ажилтнууд нь, аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмжийг чадварлагаар шалгахад хэрэглэх стандарт сорилын биетийг ашиглах зааварчилгаа авсныг;
 - (5) өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийн аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж буй аливаа үзлэгийн төхөөрөмжид Даргын хүлээн зөвшөөрөхүйц арга хэлбэрээр сорилт хийдэг болохыг.

Хүмүүс, эд зүйлс, бодис болон тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг хийх

- (b) Аюулгүйн үзлэг хийх гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:
- (1) аюулгүйн үзлэг болон шалгалт хийгдэж буй цэг бүрт, аливаа этгээд өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрэхээс өмнө тухайн этгээдэд аюулгүйн үзлэгээр заавал орохыг анхааруулсан дараах мэдээллийг байрлуулах:
 - (i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэгийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэй хийдэг болохыг;
 - (ii) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан аливаа этгээдийг тухайн цэгээр нэвтрүүлэхгүй болохыг;
 - (2) хэрэв өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд аюулгүйн үзлэг хийгдэж байгаа бол, аюулгүйн үзлэг хийгдэх хүн бүрд дараах зүйлийг мэдэгдэх:
 - (i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэгийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэй хийдэг болохыг;

- (ii) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан аливаа этгээд тухайн өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсийг орхин гарахыг шаарддаг болохыг;
- (3) Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу дараах бүртгэл хийдэг болохыг бататгах:
 - (i) тухайн аюулгүйн үзлэгийн арга;
 - (ii) Сайдын, эсхүл Даргын шаардсан, аюулгүйн үзлэгийн үргэлжлэх хугацаа;
 - (iii) аюулгүйн үзлэгт хамрагдсан хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийн тоо;
- (4) хэрэв зөвшөөрөгдөөгүй эд зүйл илэрсэн бол, дараах бүртгэл хийгдсэнийг бататгах:
 - (i) аюулгүйн үзлэг хийсэн ажилтнуудын нэрс;
 - (ii) илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлс;
 - (iii) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг аюулгүй болгох арга хэмжээ.
- (c) Аюулгүйн үзлэгийн явцад, гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:
 - (1) түүний НАХ-ын ажилтан нь аливаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг хийхдээ, тухайн этгээд аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээвэрлээгүй, эсхүл биедээ авч яваагүй болохыг бататгах;
 - (2) түүний НАХ-ын ажилтан, хэрэв зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгах;
 - (3) түүний НАХ-ын ажилтан, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүсэд аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг тухайн бүсийг орхихыг шаарддаг болохыг бататгах;
 - (4) сорилт, эсхүл шалгалтын үр дүнг дараах зорилгоор бүртгэдэг болохыг:
 - (i) аливаа аюулгүйн үзлэгийн үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд шалгах;
 - (ii) аюулгүйн үзлэг гүйцэтгэж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд шалгах.

Эд зүйлс, эсхүл бодисыг гараар шалгах

(d) Гэрчилгээ эзэмшигч, хэрэв эд зүйл, эсхүл бодис нь тэсрэх хэрэгсэл агуулсан гэж сэжиглэх аливаа шалтгаан байгаа бол, эсхүл сэжиглэгдсэн тэсрэх хэрэгсэл илэрсэн бол, түүний НАХ-ын ажилтан нь Хавсралт А.11(b)(5)-д шаардсан журмыг мөрддөг болохыг бататгах үүрэгтэй.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь, сорилт, эсхүл шалгалт хийж, тэдгээрийн үр дүнг дараах шаардлагыг бататгах зорилгоор бүртгэл хөтлөх үүрэгтэй:

- (1) аливаа гар шалгалтын үнэн зөв байдлыг 28 хоног тутамд хийдэг болохыг;

- (2) гар шалгалт гүйцэтгэж буй НАХ-ын ажилтан бүрийн ур чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд авдаг болохыг.

--oOo--